Оорийн амиа хутганы ирэн дээр аваачин байж усны аюулаас хэд хэдэн монгол хүнийг аварсан жирийн сайхан орос эрчүүлд медаль гардуулан огсон тэр нэгэн моч миний санаанд тодхон үлджээ. Медалиа зүүлгээд “их баярлалаа” гэснээ “бүгдийнх нь амийг аварч чадаагүйдээ туйлаас их харамсаж байдаг юм даа” гэж халаглан хэлсэн үг нь санаанаас гардаггүй юм.
Гадаад орны торийн медаль хүртээд баярлахаасаа илүү амийг нь аварч чадаагүй тэр хоорхий хүний толоох харууслыг сэтгэлдээ тээн, харамсаж явдаг нь түүний харц, дууны онгоноос ив илхэн, тов тодхон харагдаж, сонсогдож байсан. Оорийн амиар дэнчин тавьж, үерлэн эргэлдсэн том голоос хаа хамаагүй, замд таарсан, үл таних, харийн хүмүүсийн амийг аварч, бас аварч чадаагүй хүнийхээ толоо харамсаж явна гэдэг нь тэдний хүний мос, хүн чанар, ондор ёс суртахууны бодит хэмжээсийг ямар ч нэмэлт тайлбар сурталчилгаагүйгээр илэрхийлж байгаа хэрэг юм. Тэд сайхан сэтгэлээр, сайн үйл хийжээ. Хүний толоо сэтгэл зүрхээ зориулж хийсэн буянтай үйл болгон үнэ цэнэтэй. Харин бусдын толоо буянтай үйл хий гэж албадан шахах нь тийм ч гайхуулмаар сайн зүйл биш. Яагаад гэвэл “албадмал буянт үйл оорийн бүх үнэ цэнийг алддаг юм”.
Чиний эрхэлж буй ажил үйлс чинь оодрог сайн байгаа юу? Хамтран зүтгэгчид, удирдлагын зүгээс ажлыг чинь хэрхэн үнэлдэг вэ? Хийсэн бүтээсэн болгоныхоо үр дүнд сэтгэл тэнүүн, ханамжтай байж чадаж байна уу? Энэ асуултуудад оороо чин үнэнээр нь хариулах гээд бодоод үз. Хангалттай бус, сайн биш гэж бодогдвол шалтгааныг нь даруйхан хайж ол. Тэгэхдээ бурууг бусдаас хайлгүй эхлээд оорийн буруу зорүүг сайтар тунгаа. Олон, олон учир шалтгаан тодроно байх. Хийсэн ажлын чинь үр дүн тааруу байвал нэг л зүйл түүний үндсэн шалтгаан нь болсон байдаг нь анзаарагдана. Үнэн сэтгэлээ огч хийгээгүй ажил үйл бүхний үр дүн үжиршиж урагдах дохсон бос даавуутай адил хэврэг байдгийг чи аяндаа ойлгоно. Тиймээс том бага гэлтгүй аль ч ажилд ухаанаа зарахаас дутуугүй сэтгэлээ шингээж тогс сайн хий.
Сайн үйлс бүтээе гэж байгаа бол алгуурлаж хойшлуулах хэрэггүй. Аливаа алгуур нуршуу бүхэн ухаалаг бус, үр дүн нь од шиг хол. Сайн үйл хийе гэж сэтгэлдээ бодон суух нь сайн үйл бүтээчихсэн ч хэрэг биш. “Сайн үйл хийхийн тулд хэтэрхий удаан боддог хүнд сайн хүн байх хугацаа байхгүй” гэж хэлсэн сургамжит үг байна. Сайн хүн байж чадахгүй байсаар насаа барж болох тул алгуурлаж болохгүй. Хурдан шуурхай байх нь аливаа үйл хэргийн амин чухс нь. Эрт боссон шувуухай от олж иднэ гэсэн үг ч бий. Сайн үйл бүтээх оодрог үзлээ ямар ч бэрхшээл тохиолоо гэсэн хаяж гээж бүү орхи. Чамд хэчнээн боломжгүй мэт бодогдсон ч боломж үргэлж байдагт эргэлзэх хэрэггүй. “Оодрог үзэлтэн аливаа хүнд хэцүү нохцол байдалд зовхон боломжийг нь олж хардаг, гутранги үзэлтэн аливаа боломж гарах болгонд бэрхшээлийг нь олж хардаг”. Та нарыг зовхон боломжийг нь олж хардаг оодрог үзэлтэн байгаасай гэж үүнийг хэлж байгаа юм шүү.
Яг одоо чамд хэцүү, зүтгүү байвал үүрдийн зовлонт хувь тавилан мэтээр гуниглан бүү хүлээж ав. Нар байнга нэг газраа тусдаггүй. Оноодор сүүдэртэй байгаа чиний эргэн тойронд нар тусч л таарна. Зүүний сүвэгчин чинээ нүхээр ч сайн үйлсийн гэгээ тусна. Гагцхүү сайн үйлс бүтээх хүслээ орхиж болохгүй, залхуурч хэрэггүй. Залхуу хонинд ноос нь хүртэл тээг болдог гэсэн үг бий. Залхуу хүнд тээг болох зүйл захаас аван байна. Юу ч хийхгүй залхуурч суугаа хүн сайн үйл хийх нь байтугай муу юм хийхэд биеэ алгуур бэлдэж суудагаа мэд. Хүн сайн үйлийг шагнуулах захиалгаар юм уу шийтгүүлэх айдсаар хийхийн аль аль нь зохисгүй. Аль ч тохиолдолд сайн үйл нь үнэлгээгүй, ялих шалихгүй зүйл болон үлдэнэ. Чиний тусын тулд сайхан сэтгэлээр үйлдэж байгаа сайн үйлсийг чи ашиглах хэрэгтэй. Гэхдээ хортойгоор ашиглаж болохгүй гэсэн мэргэн ухааны алтан

дvрмийг зорчихгvй байх ёстой.
Муу хvмvvс, тэнэг хvмvvст сайн vйл хийснээр чамд сайн зvйл авчирна гэж хvлээх хэрэггvй. Тэнэг хvмvvст сайн зvйл хийх нь нуур цоором рvv аяга ус нэмж хийхтэй л адил. “Муу хvнд сайн vйл хийх нь сайн хvнд муу vйл хийхийн адил аюултай”. Аман дээрээ сайн хvн, ажил амьдрал дээр сайн хvн хоёрыг ялгаж салгаж сур. Зовхон аман дээрээ сайн хvн давхар давхар олиггvй байдгийг мэд. Бас, сайн мууг ялгадаггvй хvнд сайхан сэтгэлийн тус хэрэггvйг ойлго.
Ганцхан хар толгойгоо хоохойлоод, хорхойд хоргvй гэлдэрч явах нь тийм ч бахархмаар vйл биш. Хvмvvс чиний толоо сайхан сэтгэлээр тоолж барахгvй сайн зvйл хийсэн, хийх ч болно. Хамгийн наад зах нь эцэг эх тань улаан нялзрай байхаас чинь одий хvртэл чиний толоо хиргvй тунгалаг, ариун хайр сэтгэлээ зориулж ирсэн нор их ходолмор нь vнэлгээгvй, vнэ байхгvйдээ биш, vнэлэх аргагvй далай мэт том байдагт утга учир нь байгаа юм. Дор хаяж vvнийг ухаар. Тэгэхээр чи юуны урьд “хvний толоо хийх ажил байдаг” гэдгийг сэтгэлдээ бат суулган тогтоож ав. Тэгээд зогсохгvй хvмvvсийн толоо хийх ажлаа чин сэтгэлээсээ сайн хий, хvнд тусла! Бусдын тусыг авах, бусдад туслахдаа бодож хэрэгжvvлэх нэг чухал зарчим бий. Энэ нь “оорт чинь vзvvлсэн тусыг бvv март, харин чи оороо бусдад vзvvлсэн тусаа мартах хэрэгтэй” гэсэн зарчим. Оорийнхоо буянт vйлсээр ихэрхэн бvv гайхуул. Оорийнхоо буянт vйлсээр гайхуулдаг хvнээс ихэд болгоомжил. Чиний vзvvлсэн тусыг чи оороо бус, тусыг хvртсэн хvн санаж явах ёстой. Зовхон санах, санагалзах бус талархаж явах ёс суртахууны vvрэгтэй. Харин чи бусдын vзvvлсэн тус нэмэрт сэтгэл зvрхний угаас талархахаа мартуузай. Огоомор богоод сэтгэл харамгvй байх нь хvний сайн чанаруудын нэг мон.
Бусдад сайн vйл бvтээж байгаа хvн оортоо ч сайн vйлийг хамт бvтээж, буян хурааж байдаг. Хvний толоо хийсэн сайн сайхан vйлийнхээ vр дvнг харж, эрэгцvvлэн бодохоор асар их хоор баярыг сэтгэл зvрхэндээ хураан мэдэрнэ. Энэ нь оорт нь ирж байгаа сэтгэл ханамж, баяр баясгалан, сайн сайхан vйл мон билээ. Сайн хvн муу юм хийнэ гэдэг хамгийн аймшигтай. Тийм болохоор сайн хvнээр муу юм хийлгэж хэрхэвч болохгvй. Хvмvvсийг сайн vйлс бvтээснийх нь толоо хvндэтгэх ч хэрэгтэй, хайрлах ч хэрэгтэй. Мон, сайн vйлс тодийлон бvтээгээгvй боловч хvмvvст хор хvргэж, муу зvйл авчраагvй тэр хvмvvсийг бас хvндэтгэх нь зvйн хэрэг. Сайхан сэтгэлтэй хvний сайн vйлс гагцхvv магтаал хvлээх гавьяатай. Сайн vйлст жижиг зvйл гэж байдаггvй. Бага гэлгvй, сайхан сэтгэлээр сайн vйлийг алхам алхмаар бvтээцгээе.